



**ӨМГӨӨЛЛИЙН “ОНЧ НҮҮДЭЛ” ХХН-ИЙН ГИШҮҮН
ӨМГӨӨЛӨГЧ
ШАГДАРСҮРЭНГИЙН АЛТАНГАДАС**



2024 оны 2 сарын 26 өдөр

№

Улаанбаатар хот

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

Хяналтын журмаар гомдол гаргах нь

“Ховор Маргад” ХХК-ны шүүхэд дараах нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан

1. “Ховор Маргад” ХХК-ийн 2023.04.07-ны өдөр гаргасан 22/26 тоот хүсэлтийн дагуу шийдвэр гаргахаас татгалзсан Байгаль орчин аялал жуулчлалын яамны тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр гүйцэтгэгч А.Энхжаргалын 2023.05.18-ны өдрийн 08/2786 тоот албан бичгээр ирүүлсэн татгалзлыг хууль бус болохыг тогтоож “Ховор маргад” ХХК-ийн 2023.04.07-ны өдөр гаргасан 22/26 тоот -ны өдрийн хүсэлтийн дагуу шаардагдах захиргааны акт гаргахыг хариуцагчид даалгуулах “
2. БОАЖ-ын сайдын 2023.08.07-ны өдрийн A/277 тоот шийдвэрийг хүчингүй болгуулах

Тус нэхэмжлэлтэй хэргийн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023.11.20-ны өдрийн 0810 тоот шийдвэрээр нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. Гэтэл хариуцагчийн гаргасан давж заалдах гомдлыг хэлэлцсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024.01.18-ны өдрийн 52 тоот магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Магадлалыг дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөх боломжгүй байх тул хяналтын гомдол гаргаж байна.

1. ЗХШХШТХ-ын 123..2.1-д “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах” үндэслэлээр

Үйл баримтын талаар товч

Өмнөх шүүхийн шийдвэр магадлалаар

“Нью тур” ХХК нь Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд БОАЖ-ын сайдын 2015.05.29-ны өдрийн A/222 дугаартай тушаалыг илт хууль бусад тооцуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан.

Тус нэхэмжлэлтэй хэргийг Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022.09.30-ны 0719 тоот шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаан 2022.12.14-ны өдрийн 0788 тоот магадлалаар ЗХШХШТХ-ын 106.3.11-д зааснаар БОАЖ-ын сайдын 2015.05.29-ны өдрийн A/222 дугаартай тушаалын “Ховор маргад” ХХК-д холбогдох хэсэг, БОАЖА-ны тусгай хамгаалалттай бус нутгийн удирдлагын газрын даргын 2015.06.10-ны өдрийн “Тусгай

хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах №2015/86 тоот гэрчилгээ, гэрчилгээний хавсралтыг тус тус 6 сарын хугацаатайгаар түдгэлзүүлж шийдвэрлэсэн.

Тус магадлал хуулийн хүчин төгөлдөр болсон бөгөөд бидний зүгээс хариуцагч БОАЖ-ын сайдад хандан 2023.04.07-ны өдөр гаргасан 22/26 тоот -ны өдрийн албан бичгээр шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр магадлалын дагуу шинэ захиргааны акт гаргаж, Ховор маргад ХХК-ийн газар ашиглагчийн эрхийг сэргээж өгнө үү гэх хүсэлт гаргасан

Гэвч Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас төлөөлж Байгаль орчин аялал жуучлалын яамны тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр гүйцэтгэгч А.Энхжаргалын 2023.05.18-ны өдрийн 08/2786 тоот албан бичгээр “Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022.09.30-ны 0719 тоот шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаан 2022.12.14-ны өдрийн 0788 тоот магадлал, МУДШ-ын Захиргааны хэргийн танхимын нийтийн шүүгчдийн хуралдааны 2023 оны 80 тоот тогтоолоор Богд хан Уулын дархан цаазат газрын бага тэнгэрийн ам дах газрын маргааны шийдвэрлэсэн тул тус яамнаас аливаа шийдвэр гаргах боломжгүйг мэдэгдье” гэх хариуг өгсөн.

Иймд “Ховор маргад” ХХК нь НЗХАШШ-д шүүхийн шийдвэрийн албадан биелүүлэх захирамж гаргуулж, гүйцэтгэх хуудас бичүүлэх хүсэлт гаргасан.

Үүний дагуу НЗХАШШ-ийн шүүгчийн 2023.06.12-ны өдрийн 4951 тоот “Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай” захирамж, 2023.06.12-ны 128/ГХ/2023/0134 тоот Гүйцэтгэх хуудас бичигдэн НШШГГ-т болон БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэд НЗХАШШ-ын 2023.06.20-ны 44 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Гэвч Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023.08.01-ны өдрийн А/277 тоот тушаалаар “Богдхан уулын дархан цаазат газрын Бага тэнгэрийн аманд “Ховор маргад” ХХК-д олгосон 1,18 га газар олгосон БОАЖ-ын сайдын 2015.05.29-ны А-222 тоот тушаалын “Ховор маргад” ХХК-д холбогдох хэсгийн шүүхийн шийдвэрийн дагуу хүчингүй болсонд тооцусгай” гэжээ.

Иймд “Ховор Маргад” ХХК нь Ховор Маргад” ХХК-ийн 2023.04.07-ны өдөр гаргасан 22/26 тоот хүсэлтийн дагуу шийдвэр гаргахаас татгалзсан Байгаль орчин аялал жуулчлалын яамны тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр гүйцэтгэгч А.Энхжаргалын 2023.05.18-ны өдрийн 08/2786 тоот албан бичгээр ирүүлсэн татгалзлыг хууль бус болохыг тогтоож “Ховор маргад” ХХК-ийн 2023.04.07-ны өдөр гаргасан 22/26 тоот -ны өдрийн хүсэлтийн дагуу шаардагдах захиргааны акт гаргахыг хариуцагчид даалгуулах, БОАЖ-ын сайдын 2023.08.07-ны өдрийн А/277 тоот шийдвэрийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргасан.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хэрхэн хоорондоо хууль хэрэглэхдээ зөрүү гаргасан талаар

	НЗХАШШ-ын 2023.11.20-ны 861 тоот шийдвэрт	ЗХДЗШШ-ын 2024.01.18-ны 52
--	---	----------------------------

ЗХШХШТХ-ЫН 106.3.11-ЫГ тайлбарлан хэрэглэхэд гарсан зөрүүны талаар	Анхан шатны шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсгийн 2-т Дээр дүгнэснээр шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хариуцагч захиргааны байгууллагын шинжлэн судалж тогтоох нөхцөл байдлыг тодорхой зааж, здгээр ажиллагааг хийж, нөхцөл байдлыг бүрэн дүүрэн тогтоосны эцэст хуулийн этгээдүүдийн хэн алиных нь газар ашиглах эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр хуульд нийцүүлэн дахин шинэ акт гаргах замаар маргааныг нэг мөр шийдвэрлэх үүргийг хариуцагчид хүлээлгэсэн, өөрөөр хэлбэл "Ховор маргад" ХХК-ийн газар ашиглах эрхийг цуцлах байдлаар газрын маргааныг шүүх шийдвэрлээгүй. Гэтэл хариуцагч захиргааны байгууллага нь "Ховор маргад" ХХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн "шүүхийн шийдвэрт заасан шаардагдах захиргааны акт гаргуулах" хүсэлтэд "шүүх маргааныг шийдвэрлэсэн" гэж татгалзсан нь үндэслэлгүй, хуульд нийцэхгүй байна.	Давж заалдах шатны шүүхийн хяналт хэсгийн 3-т "Энэ шийдвэрийн агуулга нь хариуцагчид боломж олгож, дахин акт гаргах хугацаа хэтэрвэл захиргааны акт хүчингүй болох үр дагавартайг илэрхийлнэ" Хяналт хэсгийн 6-д 7. "Ховор маргад" ХХК-ийн гаргасан дээрх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан анхан шатны шүүхийн шийдвэр нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 719 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 788 дугаар магадлалыг биелүүлэх үүргийг хариуцагчид хүлээлгэхээс бус хэргийн үйл баримтын хүрээнд нэхэмжлэгчийн зөрчигдсөн гэх 1.18 га газар ашиглах эрхийг шууд сэргээх үр дагаварыг үүсгэхгүй. 12-д "Захиргааны хэргийн шүүхээс шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагаа нь дээрх хэлбэрээр тодорхойлогдохоос бус Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны А-222 дугаар тушаалын "Ховор маргад" ХХК-д холбогдох хэсэг нэгэнт хүчингүй болсон эрх зүйн үр дагавар үүссэн нөхцөлд шүүхээс үйлчлэлийг нь зогсох, эсхүл өмнө шийдвэрлэсэн тухайн актад чиглэсэн шийдвэрийг дахин гаргах үндэслэлгүй"
Дээрх дүгнэлтээр шүүхүүдийн хуулийг тайлбарлаж буй байр суурь	ЗХШХШТХ-ЫН 106.3.11 нь шүүхээс тогтоосон хугацаан дотор бодит нөхцөл байдлыг тогтоох дахин ажиллагаа хийж үр дагавартай гэж тайлбарласан.	ЗХШХШТХ-ЫН 106.3.11 нь хариуцагч байгууллагад ямар нэгэн үүрэг үр дагавар хүлээлгэхгүй бөгөөд хугацаа хэтэрсэнээр түдгэлзсэн акт хүчингүй болно.
Захиргааны Ерөнхий хуулийн 37.1 болон 37.2-д заасныг	Анхан шатны шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсгийн 3-д "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11 дэх заалтаар	Магадлалын хяналт хэсгийн 8.-д "Иймд "Х М" ХХК-иас хүчингүй болгуулахаар маргасан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн "Шүүхийн шийдвэр

тайлбарласан талаар	<p>шаардагдах захиргааны акт гаргах шүүхээс тогтоосон хугацааг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш тооцох бөгөөд шийдвэр, магадлалыг хяналтын журмаар хянан хэлэлцэхээс татгалзсан Улсын дээд шүүхийн тогтоол 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр гарсан байх тул энэ хугацаанаас 6 сарын дотор захиргааны байгууллага шүүхийн шийдвэрт заасан нөхцөл байдлыг шинжлэн судалж тогтоох ажиллагааг дахин хийж, шаардагдах захиргааны актыг гаргах үүрэг хүлээсэн, өөрөөр хэлбэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.6-д заасан шүүхийн шийдвэрээр түдгэлзсэн захиргааны акт хүчингүй болох үр дагавар 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс хойш үүсэхээр байна. Гэтэл хариуцагч захиргааны байгууллага “шүүхээс тогтоосон 6 сарын хугацаанд шийдвэрт заасан ажиллагааг огт хийлгүйгээр”, “түдгэлзсэн захиргааны акт хүчингүй болох үр дагавар үүсэхээс ч өмнө” 2023 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/277 дугаар тушаалаар “Ховор маргад” ХХК-д газар ашиглах эрх олгосон тушаалаа “шүүхийн шийдвэр биелүүлж” гэх үндэслэлээр хүчингүй болсонд тооцсон нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11, 107 дугаар зүйлийн 107.6 дахь хэсгийг буруу тайлбарлаж хэрэглэснээр хууль бус, “Ховор маргад” ХХК-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хууль бусаар халдсан ажиллагаа болжээ.</p>	<p>биелүүлэх тухай” А/277 дугаар тушаал нь захиргааны актын тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан байх шинжийг агуулаагүй гэж үзнэ” гэжээ 9. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11, 107 дугаар зүйлийн 107.6-д заасныг баримтлан гаргах шийдвэр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнд маргаан бүхий захиргааны акт хууль бус болох нь үндсэндээ тогтоогдсон байх ч шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн буюу шүүхээс нөхөн гүйцэтгэх боломжгүй тохиолдолд маргааны үйл баримтад голлох ач холбогдолтой нөхцөл байдлыг зайлшгүй тодруулах боломжийг хариуцагчид олгосон ба тогтоосон хугацаанд дахин шинэ акт гаргаагүйн улмаас /түдгэлзүүлсэн/ маргаан бүхий захиргааны акт хүчингүй болох эрх зүйн үр дагавартай болохыг тодорхойлсон, завсрын шинжтэй шийдэл байдаг.</p>
---------------------	--	--

Дээрх дүгнэлтээр шүүхүүдийн хуулийг тайлбарлаж буй байр суурь	Шүүхээс тогтоосон 6 сарын дотор татгалзсан болон хүчингүй болгох шинэ шийдвэр гаргавал тус шийдвэрүүд нь ЗЕХ-ын 37.1 болон 37.2-д заасан захиргааны акт мөн.	Шүүхээс тогтоосон 6 сарын дотор татгалзсан болон хүчингүй болгох шинэ шийдвэр гаргавал тус шийдвэрүүд нь ЗЕХ-ын 37.1 болон 37.2-д заасан захиргааны акт биш
---	--	---

2. ЗХШХШТХ-ЫН 123.2.3-Д “УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН АЛБАН ЁСНЫ ТАЙЛБАРААС ӨӨРӨӨР ТАЙЛБАРЛАЖ ХЭРЭГЛЭСЭН” ГЭЖ ЗААСАН ҮНДЭСЛЭЛЭЭР

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 01 сарын 18-ний өдрийн 0052 дугаар магадлал нь ЗХШХШТХ-ЫН 106 дугаар зүйлийн 106.3.11-д заасныг хэрэглэн шийдвэрлэхдээ Улсын дээд шүүхийн тогтоолыг зөрчиж шийдвэр гаргажээ.

Бүр тодруулбал, “УДШ-ЫН 2006.07.03-НЫ “ЗХХШТХ-ЫН ЗАРИМ ЗҮЙЛ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ” 37 тоот тогтоолын 20-Д “Хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.7-Д ЗААСАН “...ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ЦААШИД ТОДРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ГЭЖ ҮЗВЭЛ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНААС ДАХИН ШИНЭ АКТ ГАРТАЛ ЗАХИРГААНЫ УГ АКТЫГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ” АЖИЛЛАГААГ ХАРИУЦАГЧ ӨӨРӨӨ МАРГААН БҮХИЙ ЗАХИРГААНЫ АКТЫГ АЛДААТАЙ ГАРСНЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ШАЛГАН ТОГТООЖ, ШИНЭЭР ЗАХИРГААНЫ АКТ ГАРГАХ БОЛОМЖТОЙ ГЭЖ ҮЗСЭН ТОХИОЛДОЛД ХЭРЭГЖҮҮЛНЭ.

Энэ тохиолдолд шүүх маргаан бүхий захиргааны актын хэрэгжилтийг түдгэлзүүлэх бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтнаас “...ШИНЭЭР ГАРГАСАН ЗАХИРГААНЫ АКТАД ХУУЛЬД ЗААСАН ЕРДИЙН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАЖ БОЛНО” ГЭЖ ТАЙЛБАРЛАСАН ЗХХШТХ/2002/ ОНЫ 70.2.7-Д ЗААСАН ШҮҮХЭЭС ГАРАХ “ДАХИН ШИНЭ АКТ ГАРТАЛ ЗАХИРГААНЫ УГ АКТЫГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ” ШИЙДВЭРИЙН ТӨРӨЛ ЗХШХШТХ-ЫН 103.3.11-Д ЗААГДСАН БАЙГАА БИЛЭЭ.

Гэтэл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 01 сарын 18-ний өдрийн 0052 дугаар магадлалын хяnavал хэсгийн 5-8 дугаар дүгнэлтэд “...АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ҮНДЭСЛЭЛ МУУТАЙ БОЛЖЭЭ” ГЭЭД ХЯНАВАЛ ХЭСГИЙН 8-Д “... ИЙМД “ХОВОР МАРГАД” ХХК-ИАС ХҮЧИНГҮЙ БОЛГУУЛАХААР МАРГАСАН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН 2023 ОНЫ 08 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН “ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ” А/277 ДУГААР ТУШААЛ НЬ ЗАХИРГААНЫ АКТЫН ТОДОРХОЙ НЭГ ТОХИОЛДЛЫГ ЗОХИЦУУЛСАН БАЙХ ШИНЖИЙГ АГУУЛААГҮЙ ГЭЖ ҮЗНЭ” ГЭЖ БУЮУ МАРГААН БҮХИЙ АКТЫГ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ХҮРЭЭНД ГАРСАН УЧИР МАРГАХ БОЛОМЖГҮЙ ГЭЖ ШҮҮХИЙН ХЯНАЛТААС ГАРГАСАН ДҮГНЭЛТ ХИЙСЭН.

Энэ нь шууд утгаараа УДШ-ЫН 2006.07.03-НЫ “ЗХХШТХ-ЫН ЗАРИМ ЗҮЙЛ ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ” 37 тоот тогтоолыг зөрчсөн ба шүүхийн шийдвэрийн дагуу хариуцагчаас шинээр гаргасан актын улмаас нэхэмжлэгчид дарамт учирч байвал үүнийг захиргааны шинэ үлий ажиллагаанд тооцон нэхэмжлэгчийн хувьд маргах эрх нээлттэй байдаг онолын хувьд ч үл нийцэх дүгнэлт болсон.

Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5 дахь хэсэгт “УЛСЫН ДЭЭД ШҮҮХ ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛГООР ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН МАГАДЛАЛЫГ ... ХЯНАЛТЫН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ” ГЭЖ УЛСЫН ДЭЭД

шүүхийн зорилгыг тодорхойлж өгсөн. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана гэдэг нь тухай хуулийг хэрхэн хэрэглэх, тайлбарлах талаар шүүхүүд ялгаатай шийдвэр байгаа нөхцөлд нэгдмэл хэрэглээ тогтоохыг ойлгох учиртай. Нэгдмэл хэрэглээ тогтоох зорилго нь шүүх хуулийн нэг зүйл, заалтыг тохиолдол бүрт өөр өөрөөр хэрэглэх субъектив нөхцөл байдлыг хязгаарлах замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль дээдлэх зарчмыг хангах баталгаа болж өгдөг.

Манай улсын шүүхийн шинэчлэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт нь дээд шүүх зөвхөн абстракт тайлбараас гадна казуаль тайлбарын хувьд ч анхаарч үзэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Анхан шатны шүүх дээрх нөхцөл байдлыг зөв тодорхойлж шүүхийн зүгээс захиргааны байгууллагаад сонгох боломжийг олгож шүүхийн журмаар шинээр судлах боломжгүй нөхцөл байдал учирсан тул тодорхой ажиллагаануудыг хийсний улмаар дахин шийдвэр гаргах үүргийг хариуцагчид оногдуулсан Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 719 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 788 дугаар магадлалаар оногдуулсан байхад түүнийг хэрэгжүүлэлгүй буюу шүүхийн шийдвэр магадлалд дурдсан ажиллагаануудыг хийлгүйгээр гаргасан маргаан бүхий актыг хүчингүй болгож шүүхийн шийдвэр болон нэхэмжлэгчийн хүсэлтийн дагуу шинээр ажиллагаа хийж шаардагдах захиргааны акт гаргахыг даалгаж шийдвэрлэсэн нь зөв болсон.

Гэвч давж заалдах шатны шүүх тухайн маргаантай холбоотой асуудалд УДШ-ын 2006.07.03-ны “ЗХХШТХ-ын зарим зүйл заалтыг тайлбарлах тухай” 37 тоот тогтоолд заасан “...шинээр гаргасан захиргааны актад хуульд заасан ердийн журмаар гомдол гаргаж болно” гэх тайлбараас зөрүүтэй тайлбар хэрэглэж Захиргааны байгууллагаас гаргасан шинэ актыг шүүхийн шийдвэрийг биелүүлэх хүрээнд гаргасан тул захиргааны акт биш гэж үзэн шүүхийн хяналтаас гаргасан нь уг асуудалд зайлшгүй хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангаж эцэслэн шийдвэрлэх шаардлага үүсээд байгааг хүлээн авна уу.

3. ЗХХШТХ-ын 123.2.4-д “Эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” гэж заасан үндэслэлээр

Захиргааны байгууллагаас гаргаж буй шийдвэр үйл ажиллагаандaa ЗЕХ-ын 24-р зүйлд заасан бодит нөхцөл байдлыг тогтоох ажиллагааг хангалттай хэрэгжүүлэхгүй байгаагаас мөн хуулийн 42.1-д заасан сонгох боломжийг зөв хэрэглэсэн эсэхийг захиргааны хэргийн шүүх нөхөн тогтоох боломжгүйд хүрч захиргааны хэргийн шүүхээс ЗХХШТХ-ын 106.3.11-д заасан шийдвэрийг баагүй гаргаж байгаа.

Гэтэл дээрх байдлаар гаргасан шийдвэрийг захиргааны байгууллагаас ойлгохгүй байх, шийдвэрийн дараа хэрэгжүүлэх арга ажиллагааны талаар мэдлэг дутмаг байгаагаас үүдэн өөрийн эрх мэдлийг хүрээнд нотлох баримт цуглуулах, нөхцөл байдлыг тодруулах ажиллагааг явуулахгүйгээр үл барам тогтоосон хугацаан дотор түдгэлзүүлсэн актыг өөрийг нь хүчингүй болгох шийдвэр гаргасан байна.

24

Энэ тохиолдолд маргаан дахин үргэлжилж дахин шүүх дээр асуудал ирж дуусахгүй гинжин хэлхээ мэт дуусахгүй маргаан болж байна. Үүнд шүүх тайлбар хийж 106.3.11-р гаргасан шийдвэрийн зорилго үр нөлөөг тайлбарлаж шийдвэрлэхийн оронд энэ удаа бүр тогтоосон хугацаа дотор нэхэмжлэгчийн газар ашиглах эрхийг хүчингүй болгож эрхийг зөрчсөн захиргааны акттай нэхэмжлэгч маргах эрхгүй хэмээн дүгнэж нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзсан нь захиргааны хэргийн шүүх өөрийн шийдвэрийн зорилго үр нөлөөг үгүйсгээд зогсохгүй цаашлаад ЗХШХШТХ-ын 1.1-д заасан шүүхийнхээ зорилгоос урvasан шийдврийг давж заалдах шатны шүүхээс гаргалаа.

“Ховор маргад” ХХК-ийн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн зөрүүтэй байдлаар зогсохгүй захиргааны хэргийн шүүхээс ЗХШХШТХ-ын 106.3.11-ээр гаргасан шийдвэр, эс үйлдэхүйн талаар янз бүрийн үл ойлгогдом эсрэг тэсрэг шийдвэрүүд гарч байгаа нь шүүхэд итгэх иргэдийн итгэлд хор хохиролтой юм.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25.4-д заасан чиг үүргийн дагуу тус асуудлаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор гомдлыг хүлээн авч эрх зүйн тайлбар хийсэн жишиг тогтоож өгнө үү.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч

Өмгөөлөгч

Ө.Эрдэнэ-Очир

Ш.Алтангадас

